



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүнийг чөлөөлөх тухай Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дашдондовын Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын, Гаравдэмбэрэлийн Хэрлэн, Базархүүгийн Даажамба нарыг орон тооны гишүүний, Бядрангийн Лхагвасүрэн, Балганы Батбаяр нарыг орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

З.ЭНХБОЛД
